



МОНГОЛ УЛС  
МОНГОЛБАНК

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 3, Утас: 31-03-92, Факс: (976-11) 31-14-71,  
<http://www.mongolbank.mn>

2021.09.27 № A-1/963  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т


МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН С.ОДОНТУЯА ТАНАА

Таны 2021 оны 08 дугаар сарын 30-ны өдөр  
ирүүлсэн 31 тоот асуулгатай танилцаж, хариуг  
хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 10 хуудастай.


Хүндэтгэсэн

ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН

14 2986



## **ХАВСРАЛТ**

*1. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн дотоодын зах зээл дээр гаргасан төгрөг болон ам.долларын бондоос Монголбанк эзэмшиж буй эсэх, болон хэрэв эзэмшиж буй бол дүн, энэ талаар гаргасан тушаал, шийдвэр, цаашид дахин эзэмших эсэх талаар*

Монгол Улсын Их Хурлаас баталсан “Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль” болон Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, цар тахлын хүнд нөхцөлд иргэдийн санхүүгийн дарамтыг бууруулах, эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлэх зорилгоор төрийн өмчит аж ахуй нэгжүүдийн гаргасан дараах төгрөгийн бондуудыг эзэмшиж байна. Үүнд:

### **Эрдэнэс бонд:**

Монгол Улсын Их Хурлаас баталсан “Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль”-иар 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг тасалбар болгон тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийн үлдэгдэлтэй Монгол Улсын иргэний зээлийн тодорхой хэсгийг төлөхөөр зохицуулсан. Энэхүү зохицуулалтын хүрээнд төрөөс нийт 228,574 иргэний 694.9 тэрбум төгрөгийн тэтгэвэр барьцаалсан зээлийн үлдэгдлийг төлсөн байна.

Тус хуулийн 5 дугаар зүйлд Монголбанк банканд зээл олгох, санхүүгийн хэрэгсэл ашиглах эсвэл нээлттэй захын үйл ажиллагаа явуулах замаар Эрдэнэс бондыг худалдан авна гэж заасны дагуу Монголбанкнаас 2020 оны 5 дугаар сарын 5-ны өдөр “Үнэт цаас худалдан авах тухай” А-159 тоот тушаалыг гаргаж, Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн хүсэлт, хуваарийн дагуу Монголбанк банкуудаас Эрдэнэс бондыг худалдан авсан.

Монголбанк 2020 оны 5 дугаар сараас эхлэн 2021 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийг хүртэл 7 банкнаас нийт 15 удаагийн худалдан авалтаар 929.7 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэтэй 929,695 ширхэг үнэт цаасыг 724.8 тэрбум төгрөгийн зах зээлийн үнээр худалдан авч, “Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай” хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан.

### **Эрдэнэс Таван Толгой бонд:**

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтад зайлшгүй тохиолдолд төгрөгийн болон банк санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг хангаж, эдийн засгийн тодорхой салбарыг дэмжих, ингэхдээ Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд заасан үйл ажиллагаа явуулж, хуульд заасан арга, хэрэгслийг ашиглах гэж заасан. Мөн банкуудын хувьд Банкны тухай хуулийн 17 дугаар

зүйлийн 17.1, 17.4 дахь заалт болон гадаадын хөрөнгө оруулагчтай байгуулсан зээлийн гэрээний дагуу хүлээж буй хязгаарлалтын хүрээнд нэг зээлдэгчид олгох зээлийн дээд хэмжээ, нэг компанийн үнэт цаасанд хөрөнгө оруулах дээд хэмжээ өөрийн хөрөнгийн 15-20 хувиас хэтрэхгүй байх үүрэг хүлээсэн.

Энэхүү хүрээнд Монголбанк банкны хүсэлтийг үндэслэн нийт 311 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 3,110,000 ширхэг “Эрдэнэс тавантолгой ХК”-ийн гаргасан Эрдэнэс Таван Толгой бондыг анхдагч захад гаргасан нөхцөлөөр, хуримтлагдсан хүүгийн хамтаар худалдан аваад байна (Хүснэгт 1).

**Хүснэгт 1. Монголбанкны худалдан авсан Эрдэнэс Таван Толгой бондын мэдээлэл, төгрөгөөр**

№	Худалдан авсан огноо	Тоо ширхэг	Нэрлэсэн үнэ (MNT)	Эзэмшсэн хугацааны хүү (MNT)	Банкнаас худалдан авсан үнэ (MNT)	МБЕ-ийн тушаалын огноо дугаар
1	4/28/21	850,000	85,000,000,000	487,704,918.03	85,487,704,918.03	04/19/21 А-103
2	4/28/21	650,000	65,000,000,000	372,950,819.67	65,372,950,819.67	04/19/21 А-103
3	6/30/21	110,000	11,000,000,000	252,459,016.39	11,252,459,016.39	06/30/21 А-161
4	8/27/21	1,500,000	150,000,000,000	244,565,217.39	150,244,565,217.39	08/25/21 А-217
<b>Нийт</b>		<b>3,110,000.00</b>		<b>1,357,679,971.49</b>	<b>312,357,679,971.49</b>	

Эх үүсвэр: Монголбанк

*2. Валютын ханиид гол нөлөө үзүүлдэг эдийн засгийн суурь үзүүлэлтүүд хангалтгүй байна. Үүнд: Төлбөрийн тэнцэл 2021 оны 6 дугаар сард 54.2 сая ам.долларын алдагдалтай (Төлбөрийн тэнцлийн урсгал данс 2021 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 934.9 сая ам. долларын алдагдалтай гарч, энэ оны мөн үеэс 52.2 (5.9%) сая ам. доллараар өссөн). Засгийн газрын гадаад өр 8.5 тэрбум ам.доллар, Монголбанкны гадаад өр 2.2 тэрбум ам.доллар, мөнгөний нийлүүлэлт М2-ийн жилийн өсөлт (2020 оын 7 сард 21.5 их наядаас 2021 оны 7 сард 27 их наяд болж) 25.9% огцом нэмэгджээ. Мөн нийт олгосон зээлийн өрийн үлдэгдэл 19.5 их наяд төгрөг байгаагийн хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 1.2 их наяд, чанаргүй зээл 2 их наяд төгрөгт хүрч буй нөхцөлд валютын ханиийг тогтвортой байлгах талаар ямар бодлого хэрэгжүүлэхээр төлөвлөж буй талаар*

Мөнгөний нийлүүлэлт 2021 оны 8 дугаар сард 27.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 26.3 хувиар нэмэгдлээ. Үүнийг бүрэлдэхүүн хэсгээр нь задалж үзвэл гадаад цэвэр актив (ГЦА) 9 нэгж хувь, зээлийн өсөлт 13 нэгж хувийн голлох эерэг нөлөө үзүүлснээр тайлбарлагдаж байна. Тухайлбал, 2021 оны 1 дүгээр улирлаас эхлэн Эрүүл мэндээ

хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөний хэрэгжилттэй холбоотойгоор зээлийн өсөлт үргэлжлэн нэмэгдэж байна. Сүүлийн 1 жилийн хугацаанд төлбөрийн тэнцлийн ашигтай холбоотойгоор гадаад валютын албан нөөц 1 орчим тэрбум ам.доллараар нэмэгдэж, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг тэтгэв. Харин сүүлийн саруудад төлбөрийн тэнцлийн алдагдалтай холбоотойгоор гадаад валютын нөөцийн өсөлт саарч байна.

Эдийн засаг идэвхжиж байгаатай холбоотойгоор Гадаад худалдааны алдагдал тэлж, Монгол Улсын төлбөрийн тэнцэл энэ онд 300-400 орчим сая ам.долларын алдагдалтай гарах төлөвтэй байна. Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ харьцангуй өндөр түвшинд хадгалагдаж, Оюу толгойн зэсийн баяжмал дахь алтны агууламж энэ онд өмнөх оноос 2.4 дахин нэмэгдэх нь экспортод эерэг нөлөөтэй боловч Хятад-Монголын хилийн бүсэд КОВИД-19 тархах болгоомжлолын улмаас нүүрсний экспорт удааширч, улмаар нийт экспорт энэ онд жилийн 9 хувиар өсөх төсөөлөл гарсан. Харин эдийн засгийг дэмжих багц хөтөлбөрүүд хэрэгжиж, хөл хориог сулласнаар эдийн засгийн идэвхжил нэмэгдэж, уул уурхайн томоохон төсөл, дэд бүтцийн бүтээн байгуулалт үргэлжилж, дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ нэмэгдсэн зэргээс шалтгаалан бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний импорт энэ онд жилийн 33 хувиар өсөхөөр байна. Санхүүгийн дансны хувьд гадаад зээлийн ашиглалт буурах хэдий ч гадаад шууд хөрөнгө оруулалт 2020 оны түвшинд хадгалагдах, өмнөх онд банкны салбар томоохон бонд эргүүлэн төлсөн суурь үеийн нөлөөгөөр хөрөнгө, санхүүгийн дансны ашиг өмнөх оноос 16 хувиар нэмэгдэхээр тооцоолж байна. Ийнхүү эдийн засгийн идэвхжил, цар тахлын нөхцөл байдал, хилийн хязгаарлалт зэргээс шалтгаалан төлбөрийн тэнцлийн суурь нөхцөл муудах эрсдэлтэй байна. Цаашид КОВИД-19 цар тахлын тархалт Монгол болон голлох худалдааны түнш улсуудад хэр нэмэгдэх, түүний эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээ хэрхэн өөрчлөгдөх зэрэг нь тодорхой бус байдлыг нэмэгдүүлж байна.

Монголбанк төгрөгийн ханшийг зах зээлийн зарчимд суурилсан, богино хугацаанд огцом хэлбэлзэл үүсгэхгүй байхад анхаарч ажиллаж байна. Төлбөрийн тэнцэл оны эхний хагаст ашиг алдагдал бараг тэнцүү байсны илрэл нь ханш тогтвортой байснаас харагдаж байна. Цаашид эдийн засгийн суурь нөхцөлөөс хамаарч төгрөгийн ханш алгуур өөрчлөгдөх нь эдийн засагт тохиргоо хийгдэж, гадаад тэнцвэр хангагдах нөхцөл болно.


Түүнчлэн банкны системийн чанаргүй зээл 2021 оны 8 дугаар сарын байдлаар 1.8 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд энэ нь нийт зээлийн 9.1 хувийг бүрдүүлж байна. Өмнөх сартай харьцуулахад чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 0.2 нэгж хувиар, өмнөх оны эцсээс 1.5 нэгж хувиар буурсан байна. Анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл тухайн сард 1.6 их наяд төгрөг буюу нийт зээлийн 8.0 хувийг бүрдүүлж байгаа нь нийт системийн хэмжээнд эргэн төлөлтийн доголдолтой зээлийн дүнг 3.4 их наяд төгрөгт хүргэлээ. Чанаргүй зээлийг бууруулах зорилгоор “Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл”-өөр баталсан банкны системийн чанаргүй активыг бууруулах стратегийг баримтлан ажиллаж байна.

*3. Иргэд сонгогчдын зүгээс Коронавирусыг халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль батлагдсанаас хойш банкуудын эх үүсвэрийн зардал огцом буурсан боловч зээлийн жигнэсэн дундаж хүү тодорхой хэмжээнд буурахгүй байгаа бөгөөд ялангуяа иргэд, жижиг дунд бизнесүүдэд олгогдож буй зээлийн хүү бодитоор буурахгүй байгаа талаар гомдол санал ихээр ирж байна. Иймээс зээлийн хүүг бууруулах чиглэлээр ямар бодлого арга хэмжээ авах талаар тодорхой тайлбар ирүүлнэ үү.*

Монголбанкны зүгээс КОВИД-19 цар тахлын эдийн засгийн сөрөг нөлөөг бууруулахаар шат дараатайгаар авч хэрэгжүүлж байгаа мөнгөний болон макро зохистой бодлогын арга хэмжээнүүд, шинээр нэвтрүүлсэн санхүүжилтийн хэрэгслүүд, санхүүгийн хөнгөлөлтийн зохицуулалтууд нь эдийн засгийн сэргэлтийг дэмжиж, санхүүгийн салбарын тогтвортой байдалд эерэгээр нөлөөлж байна. Тухайлбал, Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны хурлаар бодлогын хүүг 11 хувиас 6 хувь хүртэл үе шаттайгаар бууруулсан бөгөөд бодлогын хүүний корридорыг хумиж  $\pm 1$  хувийн завсарт байхаар шийдвэрлэхийн зэрэгцээ төгрөгийн заавал байлгах нөөцийн (ЗБН) хувийг 10.5 хувиас 4.5 нэгжээр бууруулж 6 хувьд тогтоосон, харилцах болон хугацаагүй хадгаламжид хүү төлөхгүй байх, банк хоорондын төлбөр, тооцооны гүйлгээний шимтгэлийг бууруулсан зэрэг нь банкны салбар дахь эдийн засгийг зээлжүүлэх боломжит чөлөөт эх үүсвэрийг нэмэгдүүлэх, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг сайжруулах, эх үүсвэрийн хомсдол болон өртгийг бууруулах зэрэг эерэг нөлөөг үзүүлж байна.

Түүнчлэн, жилийн инфляц богино хугацааны нийлүүлэлтийн нөлөөгөөр бага зэрэг өсөх хандлагатай болсон хэдий ч дунд хугацаанд зорилтот түвшинтэй ойролцоо, тогтвортой байх хүлээлттэй байгаа нь иргэдийн мөнгөн хөрөнгийн бодит өгөөжийг дунд, урт хугацаанд эерэг түвшинд хадгалахуйц байдлаар хадгаламжийн хүү буурахад дэмжлэг болох юм. Ийнхүү хадгаламжийн хүү мэдэгдэхүйц тогтвортой буурч байгаа нь банкны салбар дахь эх үүсвэрийн өртгийг багасгах замаар зээлийн хүүний бууралтад нөлөөлж байна. Тухайлбал, 2021 оны 8 дугаар сарын байдлаар шинээр татсан хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 7.6% болж, өмнөх оны мөн үеэс 2.9%-аар буурсан байна. Мөн тухайн сард иргэдэд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 0.2 нэгж хувиар буурч 14.0 хувьд, аж ахуйн нэгжид олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 4.7 нэгж хувиар буурч 9.8 хувьд хүрчээ.

Зураг 1: Хадгаламжийн хүү, инфляц



Эх сурвалж: Монголбанк

Зураг 2: Зээл, хадгаламжийн хүүний зөрүү



Эх сурвалж: Монголбанк

### “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн хэрэгжилт

Монголбанкнаас зээлийн хүү бууруулахад шаардлагатай эдийн засаг, санхүү, эрх зүйн суурь орчны талаар үндэсний нэгдсэн ойлголцлыг бий болгож, бодлогын харилцан уялдааг хангахын тулд “Зээлийн хүүг бууруулах стратеги” баримт бичгийг боловсруулж, УИХ-ын 2021 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 21 дугаар тогтоолоор батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тус стратегид (1) зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах макро тогтвортой орчныг бүрдүүлэх, (2) зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах, (3) банкны үйл ажиллагааны зардлыг бууруулах, (4) хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах гэсэн 4 чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон.

Монголбанкнаас зээл, хадгаламжийн хүү буурах макро эдийн засгийн тогтвортой орчин бүрдэхэд мөнгө, макро зохистой бодлогын арга хэрэгслээр дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ банкны салбар дахь засаглалын чанарыг сайжруулах, зуучлалын үр ашгийг дээшлүүлэх үүднээс хууль эрх зүй, хяналт шалгалт зохицуулалтын арга хэмжээнүүдийг стратегийн хүрээнд үе шаттайгаар авч ажиллаж байна. Үүнд:

#### 1. Зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах, макро тогтвортой орчныг бүрдүүлэх

- Экспортын санхүүжилтийг нэмэгдүүлэхэд бодлогын хэрэгслийг ашиглах

Жижиг дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортын салбар, үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэл, 200 болон түүнээс дээш ажилтантай бөөний болон жижиглэн худалдааны салбарын аж ахуй нэгж, иргэдийг дэмжих зорилгоор 2 жилийн хугацаатай санхүүжилтийг 2020 оны 11 дүгээр сараас банкуудад олгож эхэлсэн.

Ингэхдээ хүртээмжтэй өсөлтийг бий болгох, эдийн засгийг төрөлжүүлэх ач холбогдол бүхий дээрх салбаруудын өрийн дарамтыг бууруулах зорилгоор репо арилжааны эх үүсвэрийг уг салбарын аж ахуй нэгж, иргэнд дараах нөхцөлийн дагуу олгож байна. Үүнд:

- Зээлийн хүү нь репо арилжааны хүү+4 нэгж хувиас хэтрэхгүй байх;
- Зээлийн хугацаа нь 2 жилээс доошгүй байх;
- Зээлийн дээд хэмжээ 3 тэрбум төгрөг хүртэл байх;
- Харилцагчийн хүсэлтээр үндсэн төлбөрөөс 6-с доошгүй сараар чөлөөлөх.
- Хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө барьцаалах боломжтой байх.
- Зээлийн төлбөрийг төлж барагдуулж чадахуйц бизнесийн үйл ажиллагаатай байх.
- Дахин санхүүжүүлэх зээлийн хувьд Зээлийн ангилал 2019 оны эцсийн байдлаар хэвийн байх.
- Монгол улсын хуулийн этгээд байх.

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооноос эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал гадаад, дотоод орчны төлөв, эдгээрийн ирээдүйн хандлага, эрсдэлийг харгалзан үзэж урт хугацаат репо арилжаагаар олгох санхүүжилтийн хэмжээг улирал бүр баталдаг. Үүний хүрээнд Монголбанкны Мөнгөний бодлогын хорооноос 2020 оны 4 дүгээр улиралд 230 тэрбум төгрөг, 2021 оны 1 дүгээр улиралд 250 тэрбум төгрөг, 2021 оны 2 дугаар улиралд 350 тэрбум төгрөг, 2021 оны 3 дугаар улиралд 250 тэрбум төгрөг, 2021 оны 4 дүгээр улирал 100 тэрбум төгрөгийг 2 жил хүртэл хугацаатай, дээрх салбарт олгосон төгрөгийн хэвийн зээлээр баталгаажсан үнэт цаасаар репо арилжаа хийх шийдвэр гаргав. Үүнээс тус хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш нийт 895 тэрбум төгрөгийн санхүүжилт банкуудад олгосон.

Харин 2021 оны 8 дугаар сарын байдлаар банкууд нийт 947.4 тэрбум төгрөгийн зээлийг дахин санхүүжүүлэх болон шинээр санхүүжүүлэхээр судалж, 2,939 аж ахуй нэгж, иргэнтэй 670.3 тэрбум төгрөгийн дүн бүхий гэрээг байгуулаад байна. Ингэснээр дээрх салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн өрийн дарамт тодорхой хэмжээнд буурч, шинээр зээл олгосноос зээлийн хүүг бууруулахад нөлөөлж байна.

- *Санхүүгийн зах зээлд зээл, санхүүжилтийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх:*

Цар тахалтай холбоотойгоор Засгийн газар, Монголбанкнаас хэрэгжүүлж байгаа эдийн засгийг сэргээх дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд бага хүүтэй, урт хугацаат репо санхүүжилтийн хэмжээг улирал тутам нэмэгдүүлж, “Ажлын байрыг дэмжих 3%-ийн хүүтэй зээл”, “Хөдөө аж ахуйг дэмжих зээл” болон хөнгөлөлттэй нөхцөлтэй орон сууцны ипотекийн зээлийг үргэлжлүүлэн олгож байгаа нь зах зээл дээрх хүүний түвшин буурахад бодитоор нөлөөлж байна. Ингэснээр иргэд, ААН-үүд цар тахлын үед болон түүний дараах эдийн засгийн сэргэлтийн үед бага хүүтэй, урт хугацаат зээлийн санхүүжилтээр хангагдах боломж бүрдэх юм.



- *Санхүүгийн салбарт дотоод эх үүсвэрийг гадаад валютаар бүрдүүлж байгааг бууруулах:*

Өндөр хүүтэй гадаад валютын хадгаламж болон хүү төлж байгаа гадаад валютын харилцахын эзлэх хувиар банканд олгох төгрөгийн заавал байлгах нөөцийн урамшууллыг бууруулан тооцохоор шийдвэрлэсэн. Мөн “*Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль*”-д гадаад валютын хадгаламжийг даатгалд хамруулахгүй байхаар зохицуулсан нь банкны системийн тогтвортой байдлыг хангах, банкны эх үүсвэрийн долларжилтыг бууруулах, төгрөгийн харьцангуй өгөөжийг хадгалахад эерэгээр нөлөөлнө.

- *Харилцах данс, хугацаагүй хадгаламжийн дансанд хүү тооцохгүй, хүү, түүнтэй төстэй бусад төлбөр төлөхгүй байх агуулгаар холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах:*

“*Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль*”-ийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт цар тахлын үед банкны харилцах болон хугацаагүй хадгаламжид 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хүү тооцохгүй байхаар зохицуулсан.

Цаашид Ковидын эсрэг дээрх хуулийн хэрэгжих хугацаа дуусгавар болсноор харилцах болон хугацаагүй хадгаламжид хүү төлөхгүй байх зохицуулалтыг холбогдох хууль, журамд нэмэлт өөрчлөлтийг оруулах талаар судалж, саналыг боловсруулахаар ажиллаж байна.

## **2. Зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах**

- *Банкны засаглал, хяналтыг сайжруулах*

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн УИХ-ын намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан. Тус нэмэлт өөрчлөлтөөр банкны системд нөлөө бүхий банкууд нь хуулийн зохицуулалтын дагуу 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор нээлттэй хувьцаат компани болж, санхүүгийн анхдагч зах зээлд хувьцаагаа арилжих буюу IPO гаргасан байх үүрэг хүлээсэн.

Системд нөлөө бүхий банкууд нь хувьцаагаа анхдагч зах зээлд нээлттэй гаргаснаар банкны үйл ажиллагаа ил тод нээлттэй болж, хяналтын тогтолцоо илүү боловсронгуй болох, банкны засаглал сайжрах, санхүүгийн хүртээмжтэй байдал нэмэгдэх зэрэг банк, санхүүгийн салбарын тогтвортой хөгжлийг дэмжих боломж бүрдэх юм.

- *Банкны эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх*

Зээлийн нийлүүлэлтийн тасалдлаас сэргийлж банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах зорилгоор банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээг нэмэгдүүлэх арга хэмжээг банкны

салбар дахь хөнгөлөлттэй зохицуулалтын арга хэмжээний дараагаар үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ.

### **3. Банкны үйл ажиллагааны зардлыг бууруулах**

Банкны үйл ажиллагааны зардлыг бууруулах арга хэмжээний хүрээнд банк, санхүүгийн салбарт санхүүгийн технологи, цахим шилжилтийг эрчимжүүлэн үр ашгийг нэмэгдүүлэх, банк, санхүүгийн байгууллагаас авдаг шимтгэл, хураамжийн төрөл, хэмжээг багасгах хүрээнд холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Тухайлбал, Монголбанкнаас санаачлан 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд банк хоорондын бага дүнтэй гүйлгээний шимтгэлийг 20-100 хувь бууруулахаар болсон. Ингэснээр банкны үйл ажиллагааны зардал буурахад тодорхой хувь нэмрийг оруулах бөгөөд зуучлалын үр ашиг сайжрахад эерэгээр нөлөөлнө.

Цаашид Монголбанкнаас “Зээлийн хүүг бууруулах стратеги”-д тусгагдсан хууль эрх зүй, бодлого, зохицуулалтын арга хэмжээнүүдийг коронавируст цар тахлын нөлөөлөл болон эдийн засаг, банк, санхүүгийн салбарын нөхцөл байдалтай уялдуулан үе шаттайгаар авч хэрэгжүүлж, дунд, урт хугацаанд стратегийн зорилтыг ханган ажиллах болно. Мөн макро эдийн засгийн орчин, бодлогын хүү болон Засгийн газраас хэрэгжүүлж буй эдийн засгийг сэргээх хөтөлбөрөөс хамаарч зээлийн хүү өөрчлөгдөх хүлээлттэй. Иймд Монголбанкны зүгээс эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал гадаад, дотоод орчны төлөв, эдгээрийн ирээдүйн хандлага, эрсдэлийг харгалзан үзээд инфляцын зорилтыг хангахад чиглэсэн мөнгөний бодлогыг авч хэрэгжүүлнэ.

*4. 2021 оны 7 сарын байдлаар банкны салбарын хэмжээнд 7 их наяд төгрөгийн асуудалтай зээл байна. Үүнд, 2 их наяд төгрөгийн чанаргүй зээл, 1.2 их наяд төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл, 3.7 их наяд төгрөгийн цах тахлын нөлөөнд өртсөн зээл байна. Тэгвэл нийт банкуудын хэмжээнд зээлийн үлдэгдэл нь 19.5 их наяд төгрөг байна. Энэ нь банкны зээлээс 100 төгрөг тутмын 35 төгрөг нь эрсдэлтэй гэж ойлгогдохоор байгаа бөгөөд банкны салбар туйлын хүнд байгааг илтгэж байна. Монголбанк энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэх, төлөвлөгөө стратеги гаргасан эсэх талаар*

Монголбанкнаас цар тахлын эдийн засаг дахь сөрөг нөлөөг бууруулахын тулд бизнесийн үйл ажиллагааг тасалдуулахгүй байх, идэвхжлийг дэмжих, ажлын байрыг хадгалах, иргэдийн орлого, худалдан авах чадварыг буурахаас сэргийлэх, банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах чиглэлд бодлого, зохицуулалтын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, банкны салбарын тогтвортой байдлыг хангах, тэр дундаа зээлийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх бодлогын хүрээнд Засгийн газраас хэрэгжүүлж байгаа эдийн засгийн сэргэлтийг дэмжих цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд хамтарч ажиллахаас гадна бага хүүтэй репо санхүүжилтийн зээлийн хөтөлбөрийг нэвтрүүлэх, макро зохистой бодлого болон хяналт шалгалтын журам, зааварт түр хугацааны хөнгөлөлттэй зохицуулалтуудыг мөрдүүлж байна. Үүний хүрээнд сүүлийн

18 сарын хугацаанд Монголбанкнаас зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах, зээлийн ангиллыг тодорхой хугацаанд бууруулахгүй байх зэрэг зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсээр ирлээ.

Ингэснээр зээлдэгчийн санхүүгийн байдалд дүн шинжилгээ хийж орлого тасалдсан, буурсан байдлыг харгалзан Ковид19-т өртсөн эсэхийг тогтоон, зээлдэгчдийн зээлийн эргэн төлөх нөхцөлийг дахин өөрчлөх, эргэн төлөлтийн доголдолтой зээлийн ангилал, зээлийн түүхийг түр хугацаанд бууруулахгүй, дордуулахгүй байх эсэхийг бие даан шийдвэрлэх боломжийг банкуудад нээлттэй үлдээсэн болно.

Банкуудаас ирүүлж байгаа 2021 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн байдлаарх тайлан мэдээгээр нийт 228,891 зээлдэгчийн 7.0 их наяд төгрөгийн зээл нь Ковид-19 цар тахалд өртсөн талаар мэдээлсэн байна. Үүний 67% буюу 172,139 зээлдэгчийн нийт 4.7 их наяд төгрөгийн зээлд бүтцийн өөрчлөлт хийжээ. Ковид-19 цар тахалд өртсөн, бүтэц өөрчилсөн зээлийн дүн 2020 онд эрчимтэй нэмэгдэж байсан бол 2021 оны 8 дугаар сарын байдлаар 16 хувиар буюу 1.4 их наяд төгрөгөөр буурсан нь зээлийн эргэн төлөлт цаашид тогтвортой хадгалагдах хандлагатай байгааг харуулж байна.

Одоогоор Ковид-19 цар тахалд өртсөн зээлийг ангиллаар авч үзэхэд нийт 7.0 их наяд төгрөгийн зээлийн 90.7% буюу 6.3 их наяд төгрөгийн зээл хэвийн, 9.3% буюу 732 тэрбум төгрөгийн зээл чанаргүй ангилалд байна.

Цаашид банкуудад мөрдүүлж байгаа *“түр хугацааны зохицуулалт дуусгавар болох үед зээлдэгч төлбөрөө үргэлжлүүлэн төлөх нөхцөлийг бүрдүүлсэн байх”* нь чухал бөгөөд Ковид-19 цар тахалд өртсөн зээлийн 90-ээс дээш хувийг аливаа хэлбэрээр бүтэц өөрчлөх боломжоор хангах, тус бодлогын арга хэмжээ, зохицуулалтуудыг хэзээ, хэрхэн, яаж хэвийн горимд шилжүүлэх талаарх төлөвлөгөөг цар тахлын болон эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан, богино, дунд, урт хугацаанд банкны системд төлбөрийн чадварын дарамт үүсгэхгүй байхаар боловсруулж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд банкуудад мөрдүүлж байгаа “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-тай холбоотой түр хугацаагаар мөрдүүлж байгаа хөнгөлөлттэй зохицуулалтыг 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл урьдчилан тогтоосон хуваарийн дагуу хэсэгчлэн сунгахаар шийдвэрлэлээ. Тодруулбал, зээлийн бүтэц өөрчлөх боломжийг дахин 12 сараар сунгах, зээлийн чанарын ангиллыг бууруулах хугацаа хэтэрсэн хоногийг (90 хоног болгосон байгааг) 2021 оны 8 дугаар сараас 75 хоног, 2021 оны 10 дугаар сараас 60 хоног, 2021 оны 12 дугаар сараас 45 хоног, 2022 оны 02 дугаар сараас 30 хоног, 2022 оны 4 дүгээр сараас 15 хоног болгож, хэвийн горимд аажмаар шилжүүлэхээр зохицууллаа.

Монголбанкны зүгээс хөнгөлөлттэй зохицуулалтын арга хэмжээний төлөвлөгөөнд цар тахлын болон эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан тухай бүр зохих тохируулгыг хийж ажиллах болно. Энэ нь банкны салбарын тогтвортой байдлыг хадгалах, системийн эрсдэлийг бууруулах, төлбөрийн чадварыг ханган ажиллах, эрсдэл хуримтлагдах,

эрсдэлээс хамгаалах нөөц, хөрөнгийн хуваарилалтыг зохистой түвшинд хадгалах, төлбөрийн чадварын дарамт үүсгэхгүй байх зорилттой уялдах юм.

*5. 2018 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр Төв банк /Монголбанк/-ны тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд Төв банк төсвийн ямар ч үйл ажиллагаанд оролцохгүй байх, ямар нэгэн хэлбэрээр ийм шийдвэр гаргуулахгүй байх зохицуулалтыг оруулсан. Тус хуулийн 27 дугаар зүйлийн 27<sup>4</sup>.6-д зааснаар "Засгийн газраас аливаа хэлбэрээр Монголбанкинд чиглэл өгөх, хуульд зааснаас бусад асуудлаар гэрээ, хэлцэл байгуулахыг хориглоно", 27<sup>4</sup>.7-д "Монголбанк энэ хуулийн 15, 18 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд Засгийн газарт шууд болон шууд бусаар зээл олгох, Засгийн газрын урт, богино хугацаат үнэт цаасыг анхдагч, эсхүл хоёрдогч захаас болон шууд худалдан авахыг хориглоно." гэх мэтээр хэд хэдэн шинэ заалтыг нэмсэн. Мөн Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-д "Монголбанк Засгийн газраас хараат бус байна, 31.3-т Засгийн газрын шийдвэр төрийн мөнгөний бодлогод харшилж байвал Монголбанк энэ талаар Засгийн газарт мэдэгдэнэ" зэрэг заалтууд бий. Гэтэл Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөө"-нд төсвийн шинэ чанартай зорилтуудыг Монголбанкаар санхүүжүүлэхээр болсон. Энэ нь Монголбанкны хувьд хууль зөрчиж байгаа эсэх талаар тайлбараа ирүүлнэ үү.*

Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөнд тусгагдсан ажлын байрыг болон хөдөө аж ахуйг дэмжих зээлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сангийн яам, ХХААХҮ-ийн яам, Монголбанк, Зээлийн батлан даалтын сан болон арилжааны банкууд 2021 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 7/210305/09-144 0521/87 дугаартай Ажлын байрыг дэмжих зээлийн санхүүжилтийн ерөнхий гэрээг байгуулсан. Дээрх гэрээний харилцаанд Монголбанк нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, 17 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүргийг гүйцэтгэн оролцож байна. Ажлын байрыг дэмжих зээлийн гэрээний эх үүсвэр нь банкнаас өөрийн эх үүсвэрээр олгосон, зээлийн хүүгийн дэмжлэгтэй зээл бөгөөд тус зээлийн хүүгийн дэмжлэгийг Засгийн газраас Монголбанкаар зуучлуулан банкуудад олгож байна.

Монголбанк нь Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн хувьд Засгийн газрын олгох зээлийн хүүгийн дэмжлэгийг банкуудад дамжуулан олгох, буцаан төлүүлэх болон Сангийн яамтай хамтран тус гэрээний хэрэгжилт, банкуудын аж ахуйн нэгжид олгосон зээлийн явцад хяналт тавих чиг үүрэгтэй ажиллаж байгаа нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийг зөрчөөгүй болно.